



ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЛИЙГ ИЖ БҮРЭН, ХУГАЦААНД НЬ МЭДЭЭЛЖ
БАЙХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Даланзадгад хот
2019 он



Агуулга

Аудитын тайлан бэлтгэсэн: Дарга, Тэргүүлэх аудитор П.Алтанзаяа	Товчилсон үгийн жагсаалт Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	3 4-5
Аудитын менежер Ж.Болормаа	Бүлэг 1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд	
Ахлах аудитор Т.Хонгорзул Г.Шижирболд	99.1 хувьтай хамрагдсан байна.	
Аудитор Д.Сүрэнжаргал П.Батцэцэг Д.Заяасүрэн Б.Номинцэцэг Ч.Наранбадрах	1.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдсан байна.	6
	1.2 Байгууллагууд шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан байна.	7
	1.3 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яамтай холбоотой мэдээлэл бөгөөд орон нутагт хамааралгүй болно.	7
	Бүлэг 2 Хуульд заасан мэдээллийг 95.9 хувьтай мэдээлсэн байна.	
	2.1 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д заасан байгууллагууд хугацаандаа мэдээлсэн байна.	8
	2.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг 88.2 хувьтай мэдээлсэн байна.	9-10
	Бүлэг 3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт тавьж ажилласан байна.	
	3.1 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.	11
	3.2 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.	11
	3.3 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжилт 84.4 хувьтай байна.	12
	Дүгнэлт	13
	Тэргүүлэх аудиторовын тушаал	
	Аудитаар илэрсэн зөрчлийн хуудас	
	Хавсралтууд	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539 дугаарын утсаар харилцана уу		
ХАЯГ: Нутгийн удирдлагын ордон 303 тоот Даланзадгад сум Өмнөговь аймаг		



Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл



АУДИТЫГ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3 дахь хэсгийг тус тус үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2019 оны 01 дүгээр тогтоол, Үндэсний аудитын газрын 2019 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлийн хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг бүрэн мэдээлсэн эсэх
- Хуулийн 8 дугаар зүйлд заасан холбогдох байгууллага, албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийг биелүүлсэн эсэх

ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтнуудыг хамруулав.

АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хуулийг хэрэгжүүлэгч байгууллага аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байрлуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах, иргэд, хэрэглэгчдээс судалгаа авах зэрэг аудитын арга зүйг ашиглаж аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

АУДИТ ХИЙХЭД АШИГЛСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2016 оны “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

АУДИТ ХИЙСЭН БАГ, ХУГАЦАА

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор П.Алтанзаяа, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер Ж.Болормаа нар хянан удирдаж, ахлах аудитор Т.Хонгорзул ахлан, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Д.Сүрэнжаргал, С.Одончимэг, П.Батцэцэг, Б.Номинцэцэг, Д.Заяасүрэн, Ч.Наранбадрах нар 2019 оны 03 дугаар сарын 18-ний өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.

**Бүлэг 1**

Хуулийн үйлчлэлд хамаарах
байгууллагууд 99.1 хувьтай
хамрагдсан байна.

1.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд 99.1 хувьтай хамрагдсан байна.

- 1.1.1 Аймгийн хэмжээнд нэгдсэн цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1¹-д заасны дагуу улсын төсвийн 38 байгууллага, түүний харъяа 3 сан, орон нутгийн төсвийн 139 байгууллага, ОНӨААТ 35 үйлдвэрийн газар нийт 215 байгууллага Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэлээ байршуулсан байна.
- 1.1.2 Харин “Говийн ирээдүй” ОНӨААТҮГ, “Даланзадгад зорчигч тээвэр” ОНӨААТҮГ шилэн дансанд мэдээллээ байршуулаагүй байна.
- 1.1.3 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3²-д заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа “Таван толгой” ХК, “Гүний ус” ХХК шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршиж бүрэн хамрагдсан байна.
- 1.1.4 Улс, орон нутгийн төсвийн 215, төрийн өмчит үйлдвэрийн газар 5, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа 2 байгууллага нийт 222 байгууллага Өмнөговь аймгийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршиж, хамрагдалт 99.1 хувь байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршсан байдал

Төсвийн ерөнхийлөн захирагчид	Байгууллагын төрөл	Байгууллагын тоо	Цахим хуудас нээсэн
Яам	ТШЗ	38	38
	Сан	3	3
Орон нутгийн байгууллага	ТШЗ	109	109
	ТӨЗ	1	1
	ТТЗ	15	15
	ОНӨААТҮГ	37	35
	ААНБ	2	2
	Сан	16	16
	ТӨХК, ТӨҮГ	5	5
Нийт дүн		224	222

¹ Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд

² Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани



1.2 Байгууллагууд шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан байна.

1.2.1 Байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дугаар тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг баримтлан мэдээлж байна.

1.2.2 Гэвч зарим байгууллага иргэд олон нийтэд шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг байгууллагууд баримтлан шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим хуудсанд мэдээлж байгаа боловч, мэдээллийн самбартаа мэдээллийг бүрэн байршуулж хэвшээгүй байна.

1.3 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Сангийн яамтай холбоотой мэдээлэл бөгөөд орон нутагт хамааралгүй болно.



Бүлэг 2

Хуульд заасан мэдээллийг 95.9 хувьтай мэдээлсэн байна.

2.1 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д заасан байгууллагууд хугацаандаа мэдээлсэн байна.

2.1.1 Орон нутгийн өмчийн оролцоотой “Таван толгой” ХК, “Гүний ус” ХХК-иуд шилэн дансны цахим хуудсанд бүрэн хамрагдаж хуульд заасан мэдээлвэл зохих 6 дугаар зүйлийн 6.8.1, 6.8.2, 6.8.3 дахь мэдээллийг хугацаандаа мэдээлсэн байна.

2.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг 95.9 хувьтай мэдээлсэн байна.

2.2.1 Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээлвэл зохих 3657 мэдээллээс 3308 буюу 95.9 хувийг хугацаандаа мэдээлсэн, 200 буюу 5.4 хувийг хугацаа хоцроож мэдээлсэн, 135 мэдээлэл буюу 3.6 хувийг мэдээлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх мэдээллийг байршуулсан байдал

Хүснэгт № 2

Хуулийн заалт	Заалтууд	Мэдээлвэл зохих тоо	Мэдээлсэн		Нийт мэдээлсэн	Мэдээлээгүй
			Хугацаандаа	Хугацаа хоцроосон		
	Тухайн жилийн төсөв	220	192	14	207	6
6.1.1	ОНХС-ийн төлөвлөлт	16	15	1	16	0
	ХАА төлөвлөгөө	16	15	1	16	0
6.1.2	ТГ-ийн мэдээ	2556	2371	156	2527	29
6.1.3	Дараа жилийн төсвийн төсөл	205	152	13	165	40
	Хагас жилийн эцсийн санхүүгийн тайлан	209	200	5	205	4
6.1.4	Жилийн эцсийн санхүүгийн тайлан	215	197	6	203	12
6.1.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	214	166	4	170	44
	Нийт дүн	3657	3308	200	3509	135

2.2.2 Хүснэгтээс харахад хуулийн 6.1.1-д заасан тухайн жилийн батлагдсан төсвийг 95.6 хувь, 6.1.2-т заасан төсвийн гүйцэтгэлийн мэдээг 92.7 хувьтай тус тус мэдээлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх мэдээллийн хуулийн хэрэгжилт 95.9 хувьтай байна.



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

2.2.3 Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан долоо хоногийн дотор мэдээлвэл зохих нийт 13326 мэдээллээс 12697 буюу 95.2 хувь хугацаандаа, 618 буюу 4.6 хувийг мэдээлээгүй байна.

Мэдээлэл байршуулсан байдлыг харуулбал:

Хүснэгт 2

Хуулийн заалт	Заалтууд	Мэдээлэх тоо	Мэдээлэл		Нийт мэдээлсэн	Мэдээлээгүй	Мэдээлсэн хувь
			Хугацаандаа	Хугацаахоцорсон			
6.4.1	Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	179	176	1	177	2	98.3
6.4.4	Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт	724	660	0	660	64	91.1
6.4.5	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	7510	7146	0	7146	364	95.1
6.4.6	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	129	127	0	127	2	98.4
6.4.7	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	200	199	0	199	1	99.5
6.4.8	Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	4584	4389	0	5303	195	95.7
Нийт дүн		13326	12697	1	13612	618	96.3

2.2.4 Хуулийн 6.4 дэх мэдээллийг байршуулсан хувийг өмнөх оны аудитын дүнтэй харьцуулахад бүх заалтууд дээр буурсан байна.

2.2.5 Хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 заасан улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10,0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа, аж ахуй нэгж нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийг ЗГ-ын 2014 оны 384-р тогтоолоор батлагдсан журмын дагуу мэдээлэх үүргийг төсвийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудсаар хэрэгжүүлж байна.



Бүлэг 3

Шилэн дансны тухай хуулийн
хэрэгжилтэд тавих хяналт тавьж
ажилласан байна.

3.1 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

- 3.1.1 Тус хуулийн 3.1-д заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг сумдын ИТХ ажлын хэсэг гаргаж хяналт шалгалтыг хэрэгжүүлэн хийгдсэн хяналт шалгалтын тайланг хэлэлцэн цаашид анхаарах асуудал зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажилласан байна.
- 3.1.2 Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 заасны дагуу 2018 оны 1, 2, 3 дугаар улиралд Санхүүгийн хяналт, аудитын алба тус хуулийн хэрэгжилтэд хяналт хийж ажилласан байна.
- 3.1.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хувь хангалттай байгаа хэдий ч хуулийн хугацаанд байршуулаагүй, хугацаа хоцроох, гүйцэтгэл болон хэтрэлт хэмнэлтийн тайлбар бичээгүй, байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогч нар мэдээллээ шинэчлээгүй цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчлүүд давтагдсаар байна.
- 3.1.4 МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмын 8.2 дах заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- 3.1.5 Шилэн дансны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу цахим санд тавигдсан мэдээллийн зөрчил дутагдал, хэрэгжилтийн явцын талаар байгууллага, албан тушаалтанд тавьсан шаардлагыг хүлээн аваагүй талаар гомдол мэдээлэл иргэдийн зүгээс ирээгүй байна.
- 3.1.6 Энэ нь нэг талаар иргэд шилэн дансны мэдээллийг ашиглахгүй байгаатай холбоотой байна. Цаашид иргэдийн оролцоо, хэрэгцээ шаардлагыг нэмэгдүүлэх, шилэн дансны цахим хуудсаар авч болох мэдээллийн ач холбогдолыг сурталчилан хандалтын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

3.2 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

- 3.2.1 Өмнөх 2018 оны 3 дугаар улирлын байдлаар хийгдсэн аудитаар 1,943.1 сая төгрөгийн зөрчил илэрсэнд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаандаа үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг баримтлан ажиллах тухай албан шаардлагыг Аймгийн Засаг даргад өгсөн.



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

3.2.2 Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажилласан боловч хуулийн 3.1.1, 5.7 дахь заалтууд хангалтгүйгээс өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 84.4 хувьтай байна.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд 99.1 хувьтай хамрагдсан байна.
- Байгууллагууд шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталж мэдээлсэн байна.
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-т заасан мэдээллийг 95.9 хувьтай мэдээлсэн байна.
- *Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг 95.2 хувьтай мэдээлсэн байна.*
- Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын 6 дугаар зүйлийн 6.5-д заасан мэдээллийг мэдээллэх гэсэн заалт нь Сангийн яамтай холбоотой бөгөөд орон нутагт хамааралгүй болно.
- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлсэн байна.
- Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5 дахь хэсэгт заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.9-дэх хэсэгт заасан мэдээллийг журмыг дагуу мэдээллэж байна.
- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.
- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсэгт заасан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт 84.4 хувьтай байна.



Тайлан баталгаажуулах тушаал



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2019 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/08

Даланзадгад

“Аудитын тайлан баталгаажуулах тухай”

Төрийн аудитын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалт, мөн 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2, мөн 2017 оны А/188 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан баталсугай.
2. Аудитын тайланг УАГ-ын нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга /Н.Наранбаатар/-д хүргүүлсүгэй.
3. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивийн нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээхийг нийцлийн аудитын баг /Т.Хонгорзул/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



ПАЛТАНЗАЯА

D:Bichig hereg/Tushaal-A4



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитаар илэрсэн зөрчлийн хуудас

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг /	Хууль эрх зүйн үндэслэл	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	5	8	9
1	“Буянт хотхон” хүүхдийн зуслан - Байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар, санхүүгийн тайлан хагас бүтэн жилээр мэдээлээгүй байна.	0	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.4, 6.1.6 дэх заалтыг зөрчсөн байна.	Албан шаардлага	Дарга	Ч.Адьяа
2	Политехникийн коллеж - Дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан хагас жилээр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн 17 гүйлгээ буюу 387.0 сая төгрөг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн 4 гүйлгээ буюу 61.2 сая төгрөг, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл 8 буюу 48.8 сая төгрөг мэдээлээгүй байна.	497.0	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.4, 6.4.5, 6.4.8 дахь заалтыг зөрчсөн байна.	Албан шаардлага	Дарга	Г.Түвшинбаяр
3	Хөгжил, хөрөнгө оруулалтын газар - Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн 4 гүйлгээ буюу 50.6 сая төгрөг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн 14 гүйлгээ буюу 233.5 сая төгрөг дутуу мэдээллэсэн мөн төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 29 шийдвэр буюу 233,8 сая төгрөг мэдээлээгүй байна.	517.9	Шилэн дансны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтыг зөрчсөн байна.	Албан шаардлага	Дарга	Ц.Будгэрэл
4	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар - Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн 2 гүйлгээ буюу 18.0 сая төгрөг, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн 12 гүйлгээ буюу 209.2 сая төгрөг , төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 16 шийдвэр буюу 103.07 сая төгрөг мэдээлээгүй байна.	330.9	Энэ нь шилэн дансны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтыг зөрчсөн байна.	Албан шаардлага	Дарга	Б.Должинсүрэн
5	Статистикийн хэлтэс - Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 11 шийдвэр буюу 3.4 сая төгрөг мэдээлээгүй байна.	3.4	Шилэн дансны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн байна.	Албан шаардлага	Дарга	Б.Бямбабаатар
6	Боловсрол соёлын газар - Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн 2 гүйлгээ буюу 40.7 сая төгрөг, цалингийн зардлаас бусад таван сая	234.1	Шилэн дансны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 6 дугаар зүйлийн 6.4.5, 6.4.8 дахь заалтыг	Албан шаардлага	Дарга	Б.Бат-эрдэнэ



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

	төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн 4 гүйлгээ буюу 145.2 сая төгрөг өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 12 шийдвэр буюу 48.2 сая төгрөг мэдээлээгүй байна.		зөрчсөн байна.			
7	1 дүгээр Цэцэрлэг - Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 2017 оны 10, 11, 12 дугаар саруудад нийт 45 мэдээлэл буюу 40.8 сая төгрөг мэдээлээгүй байна.	40.8	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн байна	Албан шаардлага	Дарга	Б.Наранцэцэг
8	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал - Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн 2018 оны 3 дугаар сард 14 мэдээлэл буюу 15.9 сая төгрөг мэдээлээгүй байна.	15.9	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.4, 6.4.8 дахь заалтыг зөрчсөн байна.	Албан шаардлага	Дарга	Б.Галхүү
9	2 дугаар сургууль - Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тус бүрээр мэдээлэх 2017 оны 10 дугаар сард, 2018 оны 6,7,8,9 дүгээр сард нийт 6 гүйлгээний 250.9 сая төгрөгийн орлогын 5,1 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.	255.9	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.	Албан шаардлага	Захирал	Б.Гэрэлт-од
10	Биеийн тамир спортын хороо - Дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайлан хагас жилдээр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн 57 гүйлгээ буюу 47.2 сая төгрөг мэдээлээгүй байна.	47.2	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.4, 6.4.5, 6.4.8 дахь заалтыг зөрчсөн байна.	Албан шаардлага	Дарга	С.Түвшинбаяр
		1,943.1				